



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/357

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Швейцарын хөгжлийн агентлагийн төлөөлөл орон нутагт ажиллаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Хууль тогтоомж сурталчлах төв”-ийн нээлт, Хархорин сумын иргэдэд Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль тогтоомжийн талаар танилцуулах уулзалт, арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулж гарсан зардалд 4,254,400 (дөрвөн сая хоёр зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0692

D:My Doc. Zahiramj. Zasag darga